**БУЛГАН АЙМАГ ДАХЬ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2026/119/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2026 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Д.Батцогт<br>Утас: 70342716 Цахим хаяг: @audit.gov.mn<br><br>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>“Шинжлэн Магадлахуй ЭЗШ Аудит” ХХК-ийн захирал: С.Оргил<br>Утас: 99197346 Цахим хаяг: info@shinjlenmagadlakhui-audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........ 3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 5-9
3. Аудитын тайлан ........ 10-12
4. Аудитын илрүүлэлт ........ 12-13
5. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ........ **14**

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| БСШУЯ | Боловсрол соёл шинжлэх ухааны яам |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.02.24 № 279

танай ______ ны № ______ т

БУЛГАН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН ХОЁРДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.ОЮУНСУВД ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Булган сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Булган сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургууль нь 2025 онд 1571 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж 100 хувийн гүйцэтгэлээр санхүүжсэн.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаахаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Булган аймгийн Булган сумын Ерөнхий боловсролын Хоёрдугаар сургууль нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 4 зорилт 21 арга хэмжээний хүрээнд боловсруулан нийт багш нарын хурлаар хэлэлцүүлэн сургуулийн захирлаар батлуулан, гүйцэтгэлийн зорилтыг хангаж ажиллажээ. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан

6326050402

зорилт, хөтөлбөр арга хэмжээг 4,022.2 сая төгрөгийн батлагдсан төсвийн хүрээнд биелэлтийг хангаж ажиллаж, 87.0 хувьтай дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д. БАТЦОГТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр /

| Код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 328,187,791.15 | 164,479,068.75 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 139,363,751.29 | 16,465,684.13 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 139,363,751.29 | 16,465,684.13 |
| 3121 | Төгрөг | 139,363,751.29 | 16,465,684.13 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 139,363,751.29 | 16,465,684.13 |
| 33 | АВЛАГА | 200,865.43 | 240,675.52 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 200,865.43 | 240,675.52 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 188,623,174.43 | 147,772,709.10 |
| 351 | Түүхий эд материал | 428,260.00 | 6,467,409.20 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | - | 6,322,904.20 |
| 35130 | Эм боох материал | 428,260.00 | 144,505.00 |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 11,180,186.34 | 7,058,984.54 |
| 354 | Хангамжийн материал | 173,034,728.09 | 130,121,315.36 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 408,000.00 | 313,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 1,618,300.00 | 83,400.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 6,287,773.90 | 6,287,773.90 |
| 35450 | Барилгын засварын материал | 1,539,750.00 | 371,800.00 |
| 35460 | Хүнсний материал | 15,382,780.00 | 11,776,100.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 147,798,124.19 | 111,289,241.46 |
| 35600 | Мал амьтад | 3,980,000.00 | 4,125,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,205,346,218.03 | 2,154,218,728.25 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 2,205,346,218.03 | 2,154,218,728.25 |
| 392 | Биет хөрөнгө | 1,863,438,873.97 | 1,817,996,250.87 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,763,054,886.88 | 1,763,054,886.88 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (734,551,318.30) | (858,593,562.34) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 900,498,911.49 | 914,709,754.57 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (309,444,216.91) | (349,309,971.83) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 262,053,008.14 | 342,982,799.68 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (127,229,498.78) | (83,488,067.48) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 179,961,002.00 | 161,627,632.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (91,910,761.41) | (94,187,381.47) |
| 39217 | Ном | 21,006,860.86 | 21,200,160.86 |
| 393 | Биет бус хөрөнгө | 341,907,344.06 | 336,222,477.38 |
| 39301 | Програм хангамж | 28,424,333.00 | 28,424,333.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (2,332,988.94) | (8,017,855.62) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 315,816,000.00 | 315,816,000.00 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,533,534,009.18 | 2,318,697,797.00 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 95,838,927.30 | 59,238,338.09 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 95,838,927.30 | 59,238,338.09 |
| 413 | Өглөг | 95,838,927.30 | 59,238,338.09 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 19,895,182.58 | 11,506,810.29 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | - | 1,345,060.80 |
| 4136 | Бусад өглөг | 75,943,744.72 | 46,386,467.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 75,943,744.72 | 46,386,467.00 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,437,695,081.88 | 2,259,459,458.91 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,437,695,081.88 | 2,259,459,458.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,850,088,184.62 | 1,850,088,184.62 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,850,088,184.62 | 1,850,088,184.62 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (3,972,479,233.07) | (4,150,714,856.04) |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (4,336,605,737.18) | (4,336,605,737.18) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 364,126,504.11 | 185,890,881.14 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,560,086,130.33 | 4,560,086,130.33 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,533,534,009.18 | 2,318,697,797.00 |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,534,625,325.00 | 4,988,357,885.49 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 129,194,725.00 | 214,191,761.49 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 129,194,725.00 | 214,191,761.49 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | - | 148,266,438.29 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,350,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 36,853,300.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 109,063,138.29 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 129,194,725.00 | 59,602,419.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | | 6,322,904.20 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,405,430,600.00 | 4,774,166,124.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,125,579,200.00 | 4,022,189,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 4,022,189,200.00 |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | 2,125,579,200.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 279,851,400.00 | 751,976,924.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 279,851,400.00 | 751,976,924.00 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,377,157,749.38 | 5,164,215,826.07 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,377,157,749.38 | 5,164,215,826.07 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,282,578,839.38 | 4,903,710,486.07 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,648,953,810.54 | 3,242,362,260.60 |
| 210101 | Үндсэн цалин | 1,056,139,433.94 | 2,010,451,100.16 |
| 210102 | Нэмэгдэл | 473,293,642.26 | 960,709,704.44 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 97,215,000.00 |
| 210104 | Урамшуулал | 119,520,734.34 | 173,986,456.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 206,762,264.13 | 401,079,324.48 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 138,815,164.13 | 276,012,663.32 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,986,600.00 | 32,364,537.61 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,493,400.00 | 16,858,111.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,493,400.00 | 15,160,101.87 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 33,973,700.00 | 60,683,910.30 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 253,183,944.03 | 726,040,134.80 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,142,981.19 | 25,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 226,751,421.60 | 670,040,236.80 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,289,541.24 | 30,999,898.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,399,130.00 | 27,934,473.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 210401 | Бичиг хэрэг | 3,307,000.00 | 6,622,900.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 2,092,130.00 | - |
| 210408 | Бараа материал акталсны зардал | - | 21,311,573.80 |
| 2105 | Нормативт зардал | - | 356,100.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 356,100.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,025,000.00 | 42,073,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,025,000.00 | 42,073,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,555,839.90 | 55,006,780.98 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,555,839.90 | 55,006,780.98 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 142,698,850.78 | 408,858,111.41 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,809,800.00 | 95,778,546.73 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,850.00 | 4,124,020.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 115,885,200.78 | 308,955,544.68 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 94,578,910.00 | 260,505,340.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 94,578,910.00 | 260,505,340.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 94,578,910.00 | 260,505,340.00 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 157,467,575.62 | (175,857,940.58) |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | 2,377,682.39 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | - | 1,071.54 |
| 225003 | Хөрөнгө оруулалтын гарз | - | 1,345,000.00 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал- Үндсэн хөрөнгө | | 1,031,610.85 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | - | (2,377,682.39) |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 157,467,575.62 | (178,235,622.97) |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* / төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 2,410,487,000.00 | 4,816,674,424.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 5,056,400.00 | 42,508,300.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 5,056,400.00 | 42,508,300.00 |
| 120001 | Хувьцааны ногдол ашиг | 4,506,400.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 550,000.00 | 42,508,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 550,000.00 | 5,655,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 36,853,300.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,405,430,600.00 | 4,774,166,124.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,125,579,200.00 | 4,022,189,200.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,125,579,200.00 | 4,022,189,200.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 279,851,400.00 | 751,976,924.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 279,851,400.00 | 751,976,924.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 2,317,058,592.25 | 4,877,937,591.16 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,317,058,592.25 | 4,877,937,591.16 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,225,339,332.25 | 4,620,834,931.16 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,682,871,532.13 | 3,250,549,767.46 |
| 210101 | Үндсэн цалин | 1,056,139,433.94 | 1,932,568,429.45 |
| 210102 | Нэмэгдэл | 507,211,363.85 | 1,045,859,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 96,868,112.27 |
| 210104 | Урамшуулал | 119,520,734.34 | 175,254,025.74 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 212,334,800.00 | 401,320,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 144,387,700.00 | 272,897,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 16,986,600.00 | 32,105,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,493,400.00 | 16,052,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 8,493,400.00 | 16,052,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 33,973,700.00 | 64,211,200.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 251,825,714.22 | 724,695,074.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,142,981.19 | 25,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 226,751,421.60 | 668,695,176.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 15,931,311.43 | 30,999,898.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,025,000.00 | 27,281,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,025,000.00 | 27,281,850.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | - | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 21,555,839.90 | 80,378,792.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 3,271,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 21,555,839.90 | 77,107,192.70 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 52,726,446.00 | 136,609,447.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,795,446.00 | 116,235,147.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,931,000.00 | 20,374,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 91,719,260.00 | 257,102,660.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 91,719,260.00 | 257,102,660.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 91,719,260.00 | 257,102,660.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 93,428,407.75 | (61,263,167.16) |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 73,760,905.00 | 61,634,900.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 73,760,905.00 | 61,634,900.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 73,760,905.00 | 61,634,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 73,760,905.00 | 61,634,900.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (73,760,905.00) | (61,634,900.00) |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 19,667,502.75 | (122,898,067.16) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 139,363,751.29 |

| | | | |
|---|---|---|---|
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 139,363,751.29 | 16,465,684.13 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,850,088,184.62 | 4,560,086,130.33 | (3,972,479,233.07) | 2,437,695,081.88 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,850,088,184.62 | 4,560,086,130.33 | (3,972,479,233.07) | 2,437,695,081.88 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,850,088,184.62 | 4,560,086,130.33 | (3,972,479,233.07) | 2,437,695,081.88 |
| D01 | 2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 1,850,088,184.62 | 4,560,086,130.33 | (3,972,479,233.07) | 2,437,695,081.88 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,850,088,184.62 | 4,560,086,130.33 | (3,972,479,233.07) | 2,437,695,081.88 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 185,890,881.14 | 185,890,881.14 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,850,088,184.62 | 4,560,086,130.33 | (4,150,714,856.04) | 2,623,585,963.02 |

---

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон* /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 4,976,425,500.00 | 4,939,572,491.16 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 4,976,425,500.00 | 4,877,937,591.16 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,703,814,600.00 | 4,620,834,931.16 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,260,560,900.00 | 3,250,549,767.46 |
| 210101 | Үндсэн цалин | 2,105,811,400.00 | 1,932,568,429.45 |
| 210102 | Нэмэгдэл | 1,045,859,200.00 | 1,045,859,200.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 96,868,112.27 |
| 210104 | Урамшуулал | 108,890,300.00 | 175,254,025.74 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 407,570,000.00 | 401,320,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 277,147,600.00 | 272,897,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 32,605,600.00 | 32,105,600.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 16,302,800.00 | 16,052,800.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 16,302,800.00 | 16,052,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 65,211,200.00 | 64,211,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 724,703,600.00 | 724,695,074.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,000,000.00 | 25,000,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 668,703,600.00 | 668,695,176.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 31,000,000.00 | 3,0999,898.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 35,000,000.00 | 27,281,850.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,000,000.00 | 27,281,850.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 77,341,500.00 | 80,378,792.70 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,305,000.00 | 3,271,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 74,036,500.00 | 77,107,192.70 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 198,638,600.00 | 136,609,447.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 178,209,300.00 | 116,235,147.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,429,300.00 | 20,374,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 272,610,900.00 | 257,102,660.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 272,610,900.00 | 257,102,660.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 272,610,900.00 | 257,102,660.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **61,634,900.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 61,634,900.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 61,634,900.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 4,781,892,800.00 | 4,816,674,424.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,022,189,200.00 | 4,022,189,200.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,022,189,200.00 | 4,022,189,200.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 759,703,600.00 | 751,976,924.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 759,703,600.00 | 751,976,924.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | 42,508,300.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 5,655,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 36,853,300.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **139,363,751.29** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **16,465,684.13** |

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Булган аймгийн Булган сумын 1-р сургуулийн 2025 оны

12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллагаас, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг "Шинжлэн Магадлахуй ЭЗШ аудит ХХК"-ийн аудитын баг С.Дарьсүрэн, Б.Хоролбат нар гүйцэтгэж, гүйцэтгэх захирал С.Оргил анхан шатны чанарын хяналтыг, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Батцогт нар дараагийн шатны чанарын хяналтыг хэрэгжүүлэн ажилласан.

Булган аймгийн Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны нийт зардалыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлаас 4,325,664.4 мянган төгрөгийн 1.5 хувь 64,885.9 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75 хувиар 48,663.72 мянган мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Монгол Улсын Их Хурлаас Төрийн хэмнэлтийн тухай хуулийг 2022 оны 04 дүгээр сарын 29-нд баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах эрх бүхий байгууллага нь төрийн аудитын байгууллага байна гэж заасан. Үүний дагуу "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэл"-ийг МУЕА-ын 2022 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А/59 дүгээр тушаалаар, "Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, чиглэлийг хэрэгжүүлэх заавар"-ыг МУЕА-ын 2022 оны 11 дүгээр сарын 25-ны А/89 дүгээр тушаалаар баталж, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянаж ажилласан болно. Тус байгууллага нь цалин, шимтгэлийн зардал болон бусад зардлуудаас нийт 73,305.79 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгож төрийн сангийн харилцах дансанд үлдээсэн байна. Орон нутгийн санхүүжилтээс 10,602.68 мянган төгрөгийг хэмнэн буцаан төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Булган аймгийн Булган сумын ерөнхий боловсролын Эрдмийн өргөө сургууль нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 165 мэдээллийг бүрэн оруулж, 6 мэдээлэл хоцорч мэдээлсэн байна.

**Зөвлөмж**

*Илрүүлэлт:* Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллээс 165 мэдээллийг бүрэн оруулж, мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч", Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д "Төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч" 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна

*Шийдвэрлэсэн нь:* Шилэн дансны цахим хуудсанд мэдээлэх ёстой бүх мэдээллийг хугацаанд нь бүрэн оруулах, цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын урьдчилсан шатны ажлыг fas.audit.mn системд хийж гүйцэтгэсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчлийг арилгах, таслан зогсоох 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлж биелэлтийг бүрэн хангуулан fas системээр үнэлсэн байна. Үүнд:

- Тайлант жилд 2,044.58 мянган төгрөгийг зориулалт бус зардлын зөрчил илэрч төлбөрийн акт
- Тайлант онд шилэн дансанд оруулбал зохих мэдээллээс 6 мэдээг хугацаа хоцроон мэдээлсэн тул зөвлөмжийг тус тус хүргүүлсэн
- *Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийг 100 хувь хэрэгжүүлсэн байна.*

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | Биелэлт |
|---|---|---|

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| Төлбөрийн акт | 2 | 2,044.58 | 2 | 2,044.58 | 100.0 |
| Зөвлөмж | 1 | - | 1 | - | 100.0 |
| Нийт дүн | 3 | 2,044.58 | 3 | 2,044.58 | 100.0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа[1] илрээгүй тул залруулга хийгээгүй.

Аудитаар залруулаагүй 3 зөрчил илэрч 2 зөвлөмж, 1 төлбөрийн акт хүргүүллээ.

Аудитаар залруулагдаагүй 3 зөрчилтэй асуудлын материаллаг зөрчил нь 1,484.0 мянган төгрөг бөгөөд гүйцэтгэлийн материаллаг байдал 54,224.26 мянган төгрөгөөс бага байгаа тул **Өөрчлөлтгүй дүгнэлт** өглөө.

### 5.1 Зөвлөмж

5.1.1 *Илрүүлэлт:* Санхүүгийн прогроммыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй, бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн долоо хоногт нэгтгэн нэг удаа программд шивж оруулж, анхан шатны баримтыг ихэнхийг гараар хөтөлсөн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 “Тасралтгүй байх зарчим”, 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээ үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Цаг тухай бүрд нь орлого, зарлагын гүйлгээг программд оруулан шивж байх, санхүүгийн программыг бүрэн эзэмшиж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгөх

### 5.2 Төлбөрийн акт

5.2.1 *Илрүүлэлт:* Аймгийн боловсролын газрын 2025 оны 10-р сарын 8-ны өдрийн 01/394 албан тоотоор тус сургуулийн хөгжмийн багш Х.Золзаяаг 742,000.0 төгрөг, Х.Мөнхтотохыг 742,000.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “тасралтгүй байх” гэсэн зарчим, 13.1 “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно” гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь*: Төлбөрийг барагдуулах акт өгөх

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5.Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор, зөвлөмжийн биелэлтийг 2025 оны 6 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

**Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.**

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөг/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Санхүүгийн прогроммыг өдөр тутмын ажил гүйлгээндээ ашиглахгүй, бараа материалын зарлагыг сараар түүвэрлэн сарын сүүлийн долоо хоногт нэгтгэн нэг удаа программд шивж оруулж, анхан шатны баримтыг ихэнхийг гараар хөтөлсөн. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - | - | |
| Аймгийн боловсролын газрын 2025 оны 10-р сарын 8-ны өдрийн 01/394 албан тоотоор тус сургуулийн хөгжмийн багш Х.Золзаяаг 742,000.0 төгрөг, Х.Мөнхтотохыг 742,000.0 мянган төгрөгөөр шагнаж урамшуулсан | 1 | 1,484.0 | 1 | 1,484.0 | - | | - | | - | | - | |
| **Дүн** | **2** | **1,484.0** | **1** | **1,484.0** | | | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 171 мэдээллийг оруулахаас 165 мэдээллийг бүрэн оруулж, 6 мэдээлэл хоцорч мэдээлсэн. | | | | | | | 1 | - |
| Дүн | - | - | - | - | - | - | 1 | - |